



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/11/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:Bulgan@audit.gov.mn">Bulgan@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: <a href="mailto:Tsedenkham@audit.gov.mn">Tsedenkham@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.05.02 № 297  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХААИС-ИЙН ХАРЬЯА БУЛГАН  
АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК  
КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Гагнуурчин, Тогооч, Автомашины засварчин, Оёдолчин, Компьютерын мэргэжлээр 1 жилийн сургалтыг сумын Засаг даргын тамгын газартай хамтран орон нутагт зохион байгуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний багш, суралцагч болон мэргэжилтэй ажилтнуудад

6328050444

чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг аймгийн ИТХурал баталсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a rectangular pink official stamp. The stamp contains some faint, illegible text.

Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	929,447.8	1,020,436.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,831,902.5	4,693,569.0
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,761,350.3</b>	<b>5,714,005.3</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	22,726.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,761,350.3	5,691,278.5
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,761,350.3</b>	<b>5,714,005.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,337,764.6	4,940,259.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,083,753.4	5,010,331.6
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>254,011.2</b>	<b>(70,071.9)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>254,011.2</b>	<b>(70,071.9)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(4,505.1)	5,761,350.3
	Тайлант оны үр дүн	5,765,855.4	(70,071.9)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>5,761,350.3</b>	<b>5,691,278.4</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,337,764.6	4,857,908.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,215,365.1	4,743,866.1
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>122,399.5</b>	<b>114,042.6</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>		
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>122,399.5</b>	<b>114,042.6</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	122,399.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	122,399.5	236,442.1
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>4,215,343.5</b>	<b>4,721,208.7</b>
	Урсгал зардал	4,215,343.5	4,721,208.7
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>4,337,742.9</b>	<b>4,857,908.7</b>
	Улсын төсвөөс санхүүжих	3,786,227.9	3,955,355.6
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	516,297.2	846,068.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	35,217.8	56,484.9

## Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж нь эрхэм зорилго “Хөдөө аж ахуйн салбарын эрэлтэд нийцсэн, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх” гэж тодорхойлсон байна. Алсын хараа нь “Хөдөө аж ахуйн салбараар төрөлжсөн ногоон хөгжлийн жишиг сургууль”.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөлийн хурлаас 2025 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежид суралцагчдад олгох тэтгэлгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл зөрүүтэй байгааг анхаарч, элсэлт, төгсөлтийн бодлогыг боловсронгуй болгох цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэн, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;
2. Мэргэжлийн холбоод, зөвлөл, салбар зөвлөлтэй хамтран ажиллах ажлыг эрчимжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх талаар үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх;
3. Нарийн мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, ур чадварын уралдаанд оролцох мэргэжлүүдийг нэмэгдүүлж, ур чадварын уралдаан зохион байгуулах эрхийг олон улсын жишиг, батлагдсан журмын хүрээнд сонгогдсон эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг улирал бүр тайлагнах;

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг гарган тайлагнаж 95.6 хувьтай Боловсролын Ерөнхий газарт хүргүүлсэн байна.

### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж нь Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж Хөдөө аж ахуйн салбарын эрэлтэд нийцсэн, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг.

Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, тогтоомж, тогтоол, Сангийн сайдын баталсан журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газрын хяналт, шинжилгээний үнэлгээний газраас санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехник коллежийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний багш, суралцагч болон мэргэжилтэй ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх “Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрийг аймгийн ИТХурал баталсан байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

Тайлант онд Гагнуурчин, Тогооч, Автомашины засварчин, Оёдолчин, Компьютерын мэргэжлээр 1 жилийн сургалтыг сумын Засаг даргын тамгын газартай хамтран орон нутагт зохион байгуулсан байна.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 178 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал цэсийн 7, 11 дүгээр саруудад “оруулах мэдээлэл байхгүй” гэж буруу мэдээлсэн, хавсралт файлыг мэдээлээгүй, 5.0 сая төгрөгөөс дээш 4,953.1 сая төгрөгийн 24 орлогын, 305.1 сая төгрөгийн 28 зарлагын гүйлгээг мэдээлж ажилласан байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв байршуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өмнөх шийдвэрийн биелэлт болон өөрийн орлогын бүрдүүлэлт, бүрэн төвлөрүүлсэн эсэх, өөрийн орлогын зарцуулалтад горим сорил хэрэгжүүлж анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 356.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 203.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 142.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 10.6 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

### **Залруулсан алдаа:**

1. Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 203.0 сая төгрөгийг дутуу тооцсон.

2. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа, зөрчилд 3 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж, **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### **Албан шаардлага**

Илрүүлэлт 1: Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10 дэх заалтад заасны дагуу албан шаардлага өгнө гэснийг хангаж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Дотуур байрны хүнсний материал олгохдоо захиалгын хуудсаар олгодог, шаардах хуудас бичээгүйгээс захирал гарын үсэг зурж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5 дэх хэсгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Сургуулийн видео танилцуулга хийх зорилгоор "Рэндэ студи" ХХК-тай 6,500,000.00 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийн гэрээг байгуулж төлбөрийг олгосон ч ажил гүйцэтгээгүй авлага үүссэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дэх заалт, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.7 дах заалтад заасны дагуу албан шаардлага өгнө гэснийг хангаж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **Зөвлөмж**

Бараа материалтай холбоотой асуудал.

Илрүүлэлт 1: 10.6 сая төгрөгийн бараа материалыг захирлын гарын үсэг зурж баталгаажуулаагүй шаардах хуудсаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5 дэх хэсгийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг дутуу тооцсон.	1	203.0			1	203.0	1	203.0				
Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн.	1	0.1			1	0.1	1	0.1				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>203.1</b>			<b>2</b>	<b>203.1</b>	<b>2</b>	<b>203.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	0.0			1	0.0						

Дотуур байрны хүнсний материал олгохдоо захиалгын хуудсаар олгодог, шаардах хуудас бичээгүйгээс захирал гарын үсэг зурж, баталгаажуулаагүй байна.	1	135.8			1	135.8						
Сургуулийн видео танилцуулга хийх зорилгоор "Рэндэ студи" ХХК-тай гэрээ байгуулж төлбөрийг олгосон ч ажил гүйцэтгээгүй авлага үүссэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	6.5			1	6.5						
Захирлын гарын үсэг зурж баталгаажуулаагүй шаардах хуудсаар бараа материал зарцуулсан байна.	1	10.6					1	10.6				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>152.9</b>			<b>3</b>	<b>142.3</b>	<b>1</b>	<b>10.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6 мэдээллийг хугацаа хоцроож, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал цэсийн 7, 11 дүгээр саруудад "оруулах мэдээлэл байхгүй" гэж буруу мэдээлсэн.	1	0.0					1	1.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>					<b>1</b>	<b>1.0</b>

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагуудын багш, удирдах ажилтнуудын сургалт, спортын нөхөрсөг тэмцээнд 6.2 сая төгрөг зарцуулсан.	1	6.2					1	6.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6.2</b>					<b>1</b>	<b>6.2</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6.2</b>					<b>2</b>	<b>6.2</b>